ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020. 03. 25 № 01/942
танай ____________-ны № ____________-т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.БАДРАХБАЯР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2019 оны төсвийн гүйцэтгэл, нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawaan_Bichig\20200325SAG19.Docx

001651746

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД: САГ-2020/16/СТА-ТТЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

**Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг**
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер Ц.Хосжаргал**
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
**Аудитор С.Бат-Эрдэнэ**
Утас: 261740 Цахим хаяг: bat-erdenes@audit.gov.mn

Улаанбаатар хот
2020 он

**Аудитын гол асуудал**

- Худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчиж 164.9 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авсан;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын албан ёсны шийдвэр гараагүй байхад давсан орлогоос 76.8 сая төгрөгийн автомашин худалдан авсан;
- Олон жил болсон 50.5 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;
- Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй цаашид ашиглах боломжгүй болсон 123.9 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч данс бүртгэлээс хасаагүй;

зэрэг нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, иж бүрэн байх, тохиолдсон байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.ТЭНГИС

V10.10.10.20\Bichig_Kherog\Yawsan_Bichig\2020\0325SA\319.Docx

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Т.Бадрахбаярт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох Шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс нөхөн олгосон цалингийн зардлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, цалин, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн суутгаж байх, илүүдэлтэй болон цаашид ашиглах боломжгүй болсон биет болон биет бус хөрөнгийг актлуулах, шилжүүлэх хүсэлтийг эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх, төсвөөс үр ашиггүй зардал гаргахгүй байх, Засгийн Газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг мөрдөж хот доторх албан ажлын хэрэгцээнд хөдөлгүүрийн багтаамж багатай автомашин хэрэглэж байх зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор С.Бат-Эрдэнэ гүйцэтгэв.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/373 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. АУДИТЫН ЯВЦАД МӨРДСӨН БОДЛОГО, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

## 2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж ХХҮЕГ-ын даргын 2018 оны А/174 дүгээр тушаалаар шинэчлэн баталж мөрдөж байгаа боловч 2019 онд 3Г, Сангийн сайдын тушаалаар өөрчлөлт орсон санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн актуудыг нэмж тусгах шаардлагатай байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хяналт, мониторингийн газар Нийслэлийн Багануур, Хан-Уул, Сүхбаатар, Баянгол дүүргийн ХХҮХ, Архангай, Өвөрхангай, Ховд, Увс, Орхон, Баянхонгор, Завхан аймгийн ХХҮГ-ын 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж халамжийн үйл ажиллагааны чиглэлээр 10 төрлийн зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг газар, хэлтэс бүрээр үнэлж, Багануур, Ховд аймагт “C”, Хан-Уул, Увс аймагт “D”, Баянгол, Сүхбаатар, Өвөрхангай аймаг, Архангай аймаг, Завхан аймагт “F” үнэлгээ өгсөн бол Баянхонгор, Орхон аймгийн ХХҮГ-ын зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлээгүй байна.

Хяналт, мониторингийн газраас харьяа байгууллагуудын үйл ажиллагаа, халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн үйл ажиллагаанд 2-3 жилийн давтамжаар хяналт шалгалтыг хийж байгаа боловч нийт төсвийн зардлын дийлэнх хувийг эзэлж байгаа ХХҮЕГ-ын үйл ажиллагаа болон халамж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон Нийгмийн халамжийн төв сангийн үйл ажиллагааг шалгалтад хамруулаагүй байна.

## 2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

**2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгов. Эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг сонгосон суурь үзүүлэлт 2019 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 29,780.7 сая төгрөгийн 1 хувь буюу 297.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг сонгосон суурь үзүүлэлт болох санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 35,565.3 сая төгрөгийн 1 хувь буюу 355.7 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн зардлын дүнд өөрчлөлт орсонтой холбоотой болно.

**2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 33 төсвийн байгууллага, 2 ахмадын сангийн нийт 35 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 33 байгууллага аудитад хамрагдаж, 2 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 2 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 28 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, Баянзүрх дүүргийн ХХҮХ, БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,606.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 675.5 сая төгрөгийн 15 алдааг аудитын явцад залруулж, 15.6 сая төгрөгийн 14 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 368.7 сая төгрөгийн 17 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 546.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 54 зөвлөмжийг хүргүүллээ.

*<u>Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга</u>*

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 14.9 сая төгрөгөөр мөнгөн хөрөнгийг илүү нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 10.0 сая төгрөгөөр орлого илүү нэгтгэсэн;

*<u>Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага</u>*

*Төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн аудитаар нийт 170.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:*

1. Тус байгууллага нь автомашины хэрэгцээ нэн шаардлагатай бус байхад 2018 оны давсан орлогоос 76.8 сая төгрөгөөр Nissan teana маркийн автомашиныг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл гараагүй байхад худалдан авах ажиллагааг зохион байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16-р зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 5.6-д " Үндсэн үйл ажиллагааны орлогыг дараах эрэмбийг баримтлан хөрөнгийн зардалд зарцуулна; 5.6.1.Тухайн салбар болон байгууллагын үйл ажиллагаанд нэн тэргүүнд шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, урсгал засварын ажил;......", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө, олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4-д "Төрийн өмчит хуулийн этгээд тээврийн хэрэгсэл худалдан авах тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авна......", 3.7-д " Төрийн өмчит хуулийн этгээд автомашин худалдан авах санал ирүүлэхдээ илүүдэлтэй эсхүл ашиглалтын шаардлага хангахгүй автомашиныг худалдах, шилжүүлэх, актлах асуудлыг хамтад тавьж шийдвэрлүүлнэ" заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

2. Засгийн газрын агентлагийн орон тооны хязгаар батлах тухай 2016 оны 4 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар (Засгийн газрын 2018 оны 110, 2019 оны 278 дугаар тогтоолоор тус тус өөрчилсөн) Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын орон тооны хязгаарыг 70 байхаар тогтоосон боловч уг үндсэн орон тооны хязгаарт жолооч, харуул, үйлчлэгч зэрэг 10 төрийн үйлчилгээний орон тоо батлагдаагүйгээс тэдгээр ажилтнуудын цалин, НДШ-ийн зардлыг байр ашиглалтын үйлчилгээ зориулалт арга хэмжээний бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын эдийн засгийн ангилал дээр төлөвлөн Сангийн яамаар хянуулж, төсвийг батлуулж ирсэн бөгөөд 2019 оны гүйцэтгэлээр 93.5 сая төгрөгийн зардлыг дээрх зардлаас санхүүжүүлсэн байна.

Энэ нь Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4-т "батлагдсан төсөв, сайдын баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан агентлагийн орон тоо, цалингийн санг тогтоох", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 22 дугаар зүйлийн 22.6.3-д "төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх" заасныг болон Сангийн сайдын 2014 оны 5 тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан " Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар", 2015 оны 7 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал"-ын холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй ба

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

Төвлөрүүлсэн захирагчид 218.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмжийг өгч, менежментийн захидалд дурдсан болно.

*Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчил*

Харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,192.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 650.6 сая төгрөгийн 15 алдааг аудитын явцад залруулж, 15.6 сая төгрөгийн 14 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 198.3 сая төгрөгийн 15 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 327.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 48 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

## 2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

### 2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 47.5 сая, эцсийн үлдэгдэл 30.8 сая төгрөг болж, 16.7 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | 0 | 0 | 0 | 0 |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 47.5 | 30.4 | -17.1 | 98.7 |
| Арилжааны банк дахь харилцах | 0 | 0.4 | 0.4 | 1.3 |
| Хадгаламж | 0 | 0 | 0 | 0 |
| **Дүн** | **47.5** | **30.8** | **-16.7** | **100** |

*Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 30.8 сая төгрөгийн 0.4 сая төгрөг нь арилжааны банк дахь харилцах дансанд, 30.4 сая төгрөг нь төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Баян-Өлгий аймгийн ХХҮГ ажил, гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй 35.9 сая төгрөгийг зардалд шууд бүртгэсэн.*
- *Баян-Өлгий аймгийн ХХҮГ төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 6.0 сая төгрөгийг зарцуулснаар тайлагнаж, зардалд бүртгэсэн.*
- *Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн / Налайх дүүргийн ХХҮХ 1.7 сая, Баянзүрх дүүргийн ХХҮХ 2.5 сая, Сэлэнгэ аймгийн ХХҮГ 2.3 сая /*

### 2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 724.9 сая, эцсийн үлдэгдэл 2,016.8 сая төгрөг болж, 1,291.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 10.8 | 9.3 | (1.52) |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 3.0 | 5.7 | 2.7 |
| Татаас, санхүүжилтийн авлага | 192.6 | 1,553.7 | 1,361.1 |
| Зээлийн хүүгийн авлага | | | - |
| Бусад авлага | 518.5 | 448.2 | -70.3 |
| Зээлийн авлага | | | - |
| **Дүн** | **724.9** | **2,016.9** | **1,291.9** |

*Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын дансны үлдэгдлийн 77.0 хувийг татаас санхүүжилтийн авлага, 22.2 хувийг хувь хүн болон байгууллагаас авах авлага, 0.5 хувийг ажиллагчидтай холбогдсон авлага, 0.3 хувийг төлбөртэй үйлчилгээний авлага тус тус эзэлж байна. Авлагын үлдэгдэл өмнөх оноос өссөн нь Нийслэлийн Нийгмийн халамжийн газрын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих нийслэлийн дэд хөтөлбөр, гэр оронгүй иргэдийг дэмжих дэд хөтөлбөрийн санхүүжилтийн 1,500.0 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн харьяа байгууллагууд нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдлийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Төсвийг зохистой удирдаагүйгээс санхүүгийн тайланд шинээр авлага үүсгэсэн. /Булган аймгийн ХХҮГ 5.2 сая, Дорноговь аймгийн ХХҮГ 8.1 сая/*
- *Орхон аймгийн ХХҮГ өмнөх оноос шилжин ирсэн 5.4 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.*
- *БНСУ дахь ХНХҮТ санхүүгийн тайланд тусгагдсан 45.1 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.*

### 2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 2.2 сая, эцсийн үлдэгдэл 0 сая төгрөг болж, 2.2 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Урьдчилж гарсан зардал | 2.2 | - | -2.2 |
| **Дүн** | **2.2** | **-** | **-2.2** |

*Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 2.8.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 1,269.5 сая, эцсийн үлдэгдэл 1,247.5 сая төгрөг болж, 22.0 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Тусгай зориулалттай материал | 37.6 | 44.0 | 6.38 |
| Эм боох материал | 10.2 | 3.0 | (7.20) |
| Бэлэн бүтээгдэхүүн | 18.7 | 20.5 | 1.83 |
| Бичиг хэргийн материал | 121.4 | 81.9 | (39.52) |
| Аж ахуйн материал | 562.3 | 545.0 | (17.37) |
| Сэлбэг хэрэгсэл | 57.1 | 50.3 | (6.77) |
| Түлш, шатах тослох материал | 33.6 | 53.6 | 19.93 |
| Барилгын засварын материал | 7.7 | 7.4 | (0.28) |
| Хүнсний материал | 24.4 | 26.7 | 2.25 |
| Бусад хангамжийн материал | 363.6 | 388.0 | 24.33 |
| Мал амьтад | 32.9 | 27.3 | (5.57) |
| **Дүн** | **1,269.5** | **1,247.5** | **(22.0)** |

*Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

*Аудитын илрүүлэлт:*
- *Худалдан авсан нийт 43.5 сая төгрөгийн бараа материалыг орлого аваагүй. /Баян-Өлгий аймгийн ХХҮГ 13.0 сая, Орхон аймаг 30.5 сая /*
- *Шууд худалдан авах босго үнийн дүнгээс давсан бараа материалыг худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр шууд гэрээ байгуулсан. /Орхон аймгийн ХХҮГ 19.1 сая, Говь-Алтай аймаг 50.8 сая /*
- *Багануур дүүргийн ХХҮХ 16.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллого хийж, баталгаажуулаагүй.*

### 2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 50,391.3 сая, эцсийн үлдэгдэл 52,210.2 сая төгрөг болж, 1,818.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Биет хөрөнгө** | **43,234.3** | **44,945.9** | **1,711.59** |
| Барилга, байгууламж, орон сууц | 26,904.3 | 28,080.3 | 1,176.1 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 3029.4 | 3221.1 | 191.6 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 9,123.4 | 9,312.3 | 188.8 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 3,748.6 | 3,856.2 | 107.7 |
| Бусад үндсэн хөрөнгө | 425.7 | 463.6 | 37.9 |
| Дуусаагүй барилга, байгууламж | - | 9.5 | 9.5 |
| Ном | 2.9 | 2.9 | - |
| **Биет бус хөрөнгө** | **7,157.0** | **7,264.3** | **107.3** |
| Програм хангамж | 2524.7 | 2690.3 | 165.6 |
| Бусад биет бус хөрөнгө | 4,632.3 | 4,574.0 | (58.3) |
| **Дүн** | **50,391.3** | **52,210.2** | **1,818.9** |

*Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 277.0 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 1,015.0 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 845.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 9.9 сая, акталсан 401.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга байгууламжийн дансны үлдэгдэл 9.5 сая төгрөг байгаа нь Өмнөговь аймгийн ХХҮГ Улаан толгой дахь ахмадын хээрийн сувиллын хоолны заалны зураг төсвийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр хийигдсэнийг тус дансанд бүртгэсэн байна.

*Аудитын илрүүлэлт:*
- *Сүхбаатар дүүргийн ХХҮХ-ийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2.3 сая төгрөгийн дансны үнэ бүхий тээврийн хэрэгсэл нь биетээр оршин байхгүй байна.*

**2.8.8 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 4.1 сая, эцсийн үлдэгдэл 6.4 сая төгрөг болж, 2.3 сая төгрөгөөр өссөн байна

*Хүснэгт № 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ***Богино хугацаат өр төлбөр дүн*** | **4.1** | **6.4** | **2.3** | **100.0** |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 0.9 | 0.8 | -0.2 | 11.8 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бусад өглөг | 3.2 | 5.7 | 2.5 | 88.2 |
| ***Урт хугацаат өр төлбөр дүн*** | - | - | - | - |
| **Нийт дүн** | **4.1** | **6.4** | **2.3** | **100** |

*Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ажилчидтай холбогдсон 0.8 сая төгрөгийн, байгууллагад төлөх 5.7 сая төгрөгийн өр байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Сүхбаатар дүүргийн ХХҮХ нь хувь хүний орлогын албан татварын тайлангаар 10.2 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй зөрүүтэй илэрхийлсэн.*

### 2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 37,941.0 сая, эцсийн үлдэгдэл 38,462.4 сая төгрөг болж, 521.5 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/**

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 14,418.4 | 14,418.4 | - | 37.5 |
| Хуримтлагдсан үр дүн | 17,170.8 | 17,679.4 | 508.6 | 46.0 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 6,351.8 | 6,349.6 | (2.1) | 16.5 |
| **Дүн** | **37,941.0** | **38,447.5** | **506.5** | **100.0** |

*Эх сурвалж: ХХҮЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

ХХҮЕГ-ын харьяа 7 газар өмнөх үеийн үр дүн дансанд 3.6 сая төгрөгийн нэмэгдүүлэх, 93.3 сая төгрөгийн бууруулах бичилт хийж, нийт дүнгээр 89.3 сая төгрөгийн залруулга хийгдсэн байна. / ХХҮЕГ 0.5 сая, Булган аймгийн ХХҮЕГ 0.1 сая, Дундговь аймгийн ХХҮГ 0.3 сая, Ховд аймгийн ХХҮГ 1.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, БНСУ дахь хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв 23.5 сая, Хан-Уул дүүргийн ХХҮХ 12.5 сая, Сүхбаатар аймгийн ХХҮГ 57.3 сая төгрөгөөр бууруулсан/

### 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

2019 оны төсвийн тухай хуулиар тайлант онд 580.0 сая төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдаж бүрэн төвлөрүүлж, төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн байна.

*Хүснэгт 8.* Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Төлбөр, хураамжийн орлого | 580.0 | 580.0 | 0 | 100 |
| **Нийт дүн** | 580.0 | 580.0 | 0 | |

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 24,938.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 24,938.5 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 23,142.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 208.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 1,588.4 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 23,106.6 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч төлөвлөснөөс 35.4 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 285.8 сая төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 77.7 сая төгрөгөөр давсан байна.

Туслах үйл ажиллагааны орлого 2,300.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 711.8 сая төгрөгөөр давсан нь 12 аймгийн орлого нийт дүнгээр 47.0 сая төгрөгөөр давж биелсэн Дундговь аймгийн ХХҮГ 5.0 сая, Хөвсгөл аймгийн ХХҮГ 11.6 сая, Увс аймгийн ХХҮГ 10.1 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөг тасарсан бол, мөн ХХҮЕГ -т Бүгд найрамдах Солонгос улсад ажилчин илгээх хураамжийн 685.1 сая төгрөгийн, БНСУ дахь ХНХҮТ-ийн ханшийн зөрүүний 6.4 сая төгрөгийн орлого орсноос шалтгаалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 24,603.3 сая төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь бүлгийн дүнгээр цалин хөлс болон нэмэгдэл урамшлын болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх зардал 51.1 сая, байр ашиглалттай холбоотой, хангамж, бараа материалын зардал, нормативын зардал, эд хогшил худалдан авах, урсгал засварын зардал, томилолт зочны зардал 71.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 105.6 сая, бараа үйлчилгээний бусад зардал 1.7 сая, бусад урсгал шилжүүлгийн зардал 105.3 сая төгрөгөөр тус тус гүйцэтгэлээр хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

**Нэмэлт төсөв:** Хандив тусламжаар 955.6 сая, гадаад төсөл хөтөлбөрөөс 37.5 сая, Засгийн газрын нөөц сан түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 5,148.9 сая, дээд шатны төсвийн захирагчаас 914.2 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 445.2 сая, нийт 7,501.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил, үйлчилгээний зардалд 2,203.3 сая, бусад урсгал шилжүүлгийн зардалд 3,510.8 сая, хөрөнгийн зардалд 76.8 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,710.5 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

*Аудитаар зардлын данс, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой дараах материаллаг алдаа зөрчил илэрсэн байна. Тухайлбал:*

- *Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан / Булган аймгийн ХХҮГ 1.9 сая, Сонгино хайрхан дүүргийн ХХҮХ 4.1 сая, Төв аймгийн ХХҮГ 1.7 сая /;*
- *Дундговь аймгийн ХХҮГ төвлөрсөн халаалттай орон сууцанд амьдардаг албан хаагчдад 5.3 сая төгрөгийн түлш халаалтын дэмжлэгийг олгосон;*
- *Шатахуун зарцуулалтад хяналт сул, жолоочийн тооцооны хуудсаар гүйцэтгэлийг хянаж шатахууны хэтрэлт, хэмнэлтийг тооцож, тооцоо бодоогүй /Баянгол дүүргийн ХХҮХ 2.1 сая, Налайх дүүргийн ХХҮХ 5.5 сая, Сэлэнгэ аймгийн ХХҮГ 2.2 сая, Дорноговь аймгийн ХХҮГ 1.1 сая /;*
- *Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй автотээврийн хэрэгсэлд зарцуулсан засвар үйлчилгээний талаарх мэдээллийг автомашины техник хяналтын дэвтэрт бичилт хийж баримтжуулаагүй./БНСУ дахь ХНХҮТ 6.1 сая, Баянгол дүүргийн ХХҮХ 3.9 сая, Сэлэнгэ аймгийн ХХҮХ 6.4 сая /;*
- *Баянзүрх дүүргийн ХХҮХ 95.0 сая төгрөгийн түрээсийн гэрээг байгуулахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй;*
- *БНСУ дахь ХНХҮТ нь ажилчдад олгох байрны түрээсийн зардлыг дотоод журамд заасан хэмжээнээс илүү тооцож, нийт 22.4 сая төгрөгийг илүү олгосон;*
- *Говь-Алтай аймгийн ХХҮГ төрийн захиргааны дэс түшмэлийн сул орон тоонд төрийн албаны шалгалт өгөөгүй 2 иргэнийг томилж, 18.2 сая төгрөгийн цалин олгосон;*
- *Дархан-Уул аймгийн ХХҮГ үндсэн үйл ажиллагааны зардлаас бүтэц орон тоонд батлагдаагүй малчин, сахиулын цалинд 9.3 сая төгрөг зарцуулсан.*

## 2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Тус газар нь тайлант онд нийт 15 гэрээт ажилтан томилж, цалин, НДШ-ийн 132.1 сая төгрөгийн зардлыг 80103-210801 зардлын эдийн засгийн ангиллаас санхүүжүүлсэн ба 2020 оны 1-р улирлын байдлаар 7 ажилтныг үргэлжлүүлэн ажиллуулж байна.

**2.11. Шилэн дансны мэдээлэл**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 113 мэдээллийг хугацаанд нь, 30 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

**2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 0.7 сая төгрөгийн зөрчилд тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулсан, нийт 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.

**2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Хязгаарлалттай" дүгнэлт

Залруулагдаагүй 930.9 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 355.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай санал дүгнэлтийг өгч байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

## 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр суурьнаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт:

Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон ажилтанд ажлаас чөлөөлөгдсөн хугацааны нийт 28.9 сая төгрөгийн цалинг нөхөн олгосон болович буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 -д “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 *Эрсдэл*:

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

3.1.3 *Өгсөн зөвлөмж:*

Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг авах.

3.1.4 *Байгууллагаас өгсөн хариу, тайлбар*:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

### 3.2 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.2.1 *Илрүүлэлт*:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны А/288 дугаар тушаалаар 74 ажилтанд 141.2 сая төгрөгийн урамшуулал цалинг олгохдоо даатгуулагчаас суутгах 16.2 сая төгрөгийн болон ажил олгогчоос төлбөл зохих 17.6 сая төгрөгийн НДШ-ийг тус тус суутган тооцоогүй, нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийн тайланд тайлагнаагүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ", 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх; 32 дугаар зүйлийн 1-д "Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна": 1/Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор;....." заасныг тус тус зөрчиж, Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2 *Эрсдэл:*
Нийгмийн даатгалын тухай хууль зөрчигдөх, байгууллагын санхүүгийн тайланд он дамжсан өр төлбөр үүсэх.

3.2.3 *Өгсөн зөвлөмж*:
Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу цалин, урамшууллаас суутгавал зохих нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн суутгаж, нийгмийн даатгалын тайланд үнэн зөвөөр тайлагнаж байх.

3.2.4 *Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:*
Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

### 3.3 БИЕТ БУС ХӨРӨНГӨТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

**3.3.1 ИЛРҮҮЛЭЛТ:**
Биет бус хөрөнгийн дансанд ХХҮЕГ болон 21 аймаг, 9 дүүргийн харьяа байгууллагад ашиглаж байсан ашиглалтын лицензийн хугацаа дууссан 120.2 сая төгрөгийн дансны үнэтэй 1200 ш вирусийн программ, цаашид ашиглах боломжгүй болсон нягтлан бодох бүртгэлийн 6 тооны 3.7 сая төгрөгийн программ хангамжууд бүртгэлтэй байгаа боловч актлуулах саналыг холбогдох байгууллагад гаргаж, данс бүртгэлээс хасаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 -д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:
Ашиглах боломжгүй болсон биет бус хөрөнгийг акталж, данснаас хасаагүй байх, данс буруу ангилж бүртгэсэн байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:
Цаашид ашиглах боломжгүй болсон программ хангамжийг актлах саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлж, данс бүртгэлээс хасах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:
Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

### 3.4 ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ

3.4.1 Илрүүлэлт:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 364 дүгээр тогтоолоор тус байгууллагын эзэмшилд 125.0 сая төгрөгийн дансны үнэтэй Toyota landcruizer 200 маркийн автомашиныг балансаас балансад шилжүүлснийг 2018 онд хөрөнгийн орлогоор бүртгээгүй, холбогдох байгууллагын шийдвэргүйгээр Ховд аймгийн ХХҮГ-т ашиглуулж байгаад 2019 оны 12-р сард байгууллагын эзэмшилд авчирсан боловч автомашины хөдөлгүүр эвдэрч одоогоор ашиглах боломжгүй болсон, мөн байгууллагын эзэмшилд бүртгэлтэй Hyundai sonata 6 маркийн 28.7 сая төгрөгийн дансны үнэ бүхий автомашиныг холбогдох байгууллагын шийдвэр гараагүй байхад Баянзүрх дүүргийн ХХҮХ-т шилжүүлэн өгсөн байна.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл: Төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрх: 2-д " Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй: 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;, 31 дүгээр зүйлийн 1-д “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно”., 2 -д “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд энэ хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1-д " Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасан тус тус нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:
Төрийн өмч зориулалт бусаар ашиглагдах, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал алдагдах,

3.4.3 Өгсөн зөвлөмж:
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу илүүдэлтэй байгаа тээврийн хэрэгслүүдийг шилжүүлэх ажлыг зохион байгуулж, эрх байгууллагын шийдвэрийн дагуу данснаас хасах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:
Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

**3.5 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**
3.5.1 Илрүүлэлт:
Байгууллагын эзэмшилд биетээр ашиглагдаагүй автомашины засвар үйлчилгээнд 3.4 сая төгрөгийн зардал гаргасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл.Төсвийг зарчмыг хэрэгжүүлэх: 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5-д " батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заасантай тус тус нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:
Батлагдсан төсөв зориулалт бусаар зарцуулагдах

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:
Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

**3.6 ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ**

3.6.1 Илрүүлэлт:
Агентлагийн дарга, дэд дарга нарын хотын доторх албан ажлын хэрэгцээнд 4500 см3 хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж бүхий Toyota Land cruizer 200 маркийн 2 автомашин, 3000см3 хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж бүхий Hyundai azera маркийн автомашин тус тус хэрэглэж байгаа нь Суудлын автомашин ашиглалтын талаар авах арга хэмжээний тухай Засгийн Газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын 8-д "Төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см3-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэх, бүх шатны байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх, шатахууны зардлыг төлүүлэхийг тус тус хориглосугай" тогтоолын хавсралтаар баталсан Албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалттай тус тус нийцэхгүй байна.

3.6.2 Эрсдэл:
Шатахууныг батлагдсан нормоос илүү зарцуулах, холбогдох хууль, тогтоомж, заавар, журам зөрчих;

3.6.3 Өгсөн зөвлөмж:
ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж хот доторх ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн багтаамж багатай автомашин хэрэглэж байх.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:
Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 2,044,148.7 | 3,295,207.9 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 47,516.1 | 30,822.8 |
| 33 | АВЛАГА | 724,930.4 | 2,016,858.9 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 2,177.8 | 0.0 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 1,269,524.4 | 1,247,526.2 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **35,900,941.5** | **35,158,699.3** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 35,900,941.5 | 35,158,699.3 |
| 39200 | Биет хөрөнгө | 30,401,133.5 | 29,857,844.4 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 5,499,808.0 | 5,300,854.8 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **37,945,090.2** | **38,453,907.2** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **4,136.1** | **6,438.6** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 4,136.1 | 6,438.6 |
| 41300 | Өглөг | 4,136.1 | 6,438.6 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **37,940,954.1** | **38,447,468.6** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 37,940,954.1 | 38,447,468.6 |
